МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1911-1924

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



Шашин төрийг хослон баригч, Наран гэрэлт хаан VIII Богд Жибзундамба хутагт

Jibzundamba Khutagt, the 8th Bogd Khan, the Co-Head of Religion and State



Монгол Улсын Эх дагина, Цагаан дар-а Дондогдулам

Mother of Mongolia, Tsagaan dar-a Dondogdulam / Queen Consort/

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны тэргүүн сайдаар М.Намсрайг томилсон Богд хаантаны зарлиг

*1911.12.29* *МУ, ҮТА, Х-А6, Д-1, ХН-511, Б-4*

Order of the Bogd Khan appointing M. Namsrai as the First Justice Minister

*1911.12.29* *МУ, ҮТА, Х-А6, Д-1, ХН-511, Б-4*



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны тэргүүн сайд М.Намсрай

vvM. Namsrai, the First Justice Minister



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тамганы дардас

The seal of the Ministry of Justice

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны тэргүүн сайд М.Намсрай Богд хаантаны шагнасан тамгыг хүлээн аваад яам байгуулж, хэрэг шийтгэснийг айлтгасан айлтгал
*1911.12.29* *МУ, ҮТА, Х-А173, Д-1, ХН-75, Б-7*

Statement of M.Namsrai who received a seal from the Bogd Khan and established the ministry
*1911.12.29* *МУ, ҮТА, Х-А173, Д-1, ХН-75, Б-7*



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны албан хаагчдын тангарагийн үг.

The oath wordings of legal professionals

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС

ХӨРВҮҮЛЭГ:

*“Ум сайн амгалан болтугай. Манай Монгол Улсын шашин, төрийг туг түмэн онд бат болгохын учир бурхан номын сахиулсаны өмнө батад тангалаглах нь:*

*Манай Халхын хан, ван, гүн, засаг, Эрдэнэ шанзудба, да лам нар түшмэдээс эхлэн шар, хар болон олон бүхнээр Очирдар-а Богд гэгээнтнээ шашин, төрийг хослон баригч Наран гэрэлт, түмэн наст Богд эзэн өргөмжлөн Эрдэнийн сууринаа залаад Монгол Улсын тулгар төрийг шинэ байгуулсан цаг, бидний Монгол овгийн сайд, ноёд, түшмэд бүгдээр бурхан хааны түгээмэл өршөөлт их төрийн элдэв хэрэгт буцалтгүй шударга чигч, магад үнэнээр нэгэн сэтгэл хүчээ гаргаж зүтгэн, чин үнэнхүү түйлын санаагаар гүйцэгэсүгэй. Хэрэв илт үнэн мэт өнгөлөн, далд мэхлэн баширлах ба тэрслүү санаа үүсгэж энэхүү төрөөс урван няцах нь буй аваас тангарагын эзэн сахиулсан хоромхон зуураа илтэд буруушаан үзүүлтүгэй. Жич, үүнээс урагш энэ тухайд дутагдсан ноёд, шинэ цутган дагаар ирэгсдийг мөн тухай бүр ийнхүү бат тангараг хийлгэж, амьсгал санааг итгүүлж, нэгэн чанар болгож энх түвшин шашин төрд үүрд цэнгэлдүүлэхийг айлдан айлд.*

*Шүүх яамны эх.*



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны шүтээн Дамжин Чойжил бурхан

Damjin Choijil, the religious idol of the Ministry of Justice



**Богд хааны зарлигаар батлагдсан Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны эрхлэн шийтгэх хэргүүд.**
*1913 он. МУ, ҮТА, Х-А7, Д-1, ХН-161, Б-1*

**Bogd Khan's decree allocating all cases as the responsibility of the Ministry of Justice 1913**
*МУ, ҮТА, Х-А7, Д-1, ХН-161, Б-1*


АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС






**Иргэд хууль цаазыг сүслэн биширч, шударга номхон аж төрөхийг Бүгд ерөнхийлөн захирах яамнаас уриалсан бичиг. 1915 он.**
*МУҮТА, ТБА, Х-А2, Д-1, ХН-290, Б-1*

**A letter from the Prime Minister urging citizens to adhere to the rule of law and live a just life. 1915**
*МУҮТА, ТБА, Х-А2, Д-1, ХН-290, Б-1*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1911-1924

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**“Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийг дармаллах тухай Богд хааны зарлиг**

*1918.12.19* *МУУТА. ТБА. ХА.173, Д.1, ХН.188, Б.1*

**Bogd Khaan’s Decree to imprint the “Mongolian legal documents enforced by the Decree”**

*1918.12.19* *МУУТА. ТБА. ХА.173, Д.1, ХН.188, Б.1*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС



**Богд хааны зарлигаар дармалласан “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бүтэц, эрхлэн шийтгэх хэргийн тухай заасан нь.**

*МУУТА, ТБА, Х-А235, Д-1, ХН-3, Хууд.1-12*

**The Mongolian legal document established by the Bogd Khan’s decree stipulates the structure and proceedings of the Ministry of Justice**

*МУУТА, ТБА, Х-А235, Д-1, ХН-3, Хууд.1-12*

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1911-1924

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**Сэргээн босгогдсон Автономит Гадаад Монгол Улсын төрийн яамдын сайд, түшмэдийг томилсон Богд хаантаны зарлиг**

*1921.02.22* *МУ, ҮТА, Х-А3, Д-1, ХН-1146, Б-18*

**Order of the Bogd Khan appointing ministers and officials of the re-established Autonomous Outer Mongolia**

*1921.02.22* *МУ, ҮТА, Х-А3, Д-1, ХН-1146, Б-18*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС



**Ардын эрхтэй Засгийн газрыг байгуулж, төрийн яамдын сайд, түшмэдийг томилсныг Богд хаантанд айлтгасан айлтгал**

*1921.07.11* *МУ, ҮТА, ҮТА, Х-1, Д-6, ХН-6*

**A statement to the Bogd Khan informing him that a government with people's rights had been formed and that ministers and officials of state ministries had been appointed**

*1921.07.11* *МУ, ҮТА, ҮТА, Х-1, Д-6, ХН-6*



Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны хоёр дахь тэргүүн сайд Махасамади Далай Сэцэн хан Ц.Навааннэрин

Mahasamadi Dalai Setsen Khan Ts. Navaanneren, Second Justice Minister



Сэргээн байгуулагдсан Автономит Гадаад Монголын Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд, бэйс Чимэддорж

The Justice Minister of the newly established Autonomous Outer Mongolia, Duke Chimeddorj

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС



Ардын Засгийн Шүүх яамны сайд, бэйл Н.Магсаржав

Duke N. Magsarjav, Minister of Justice of the People's Government



Ардын Засгийн Шүүх яамны сайд Д.Содномдорж

D.Sodnomdorj, Minister of Justice of the People's Government

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**Улсын VIII Их хурлаар баталсан БНМАУ-ын хоёрдугаар Үндсэн хуулиас**
*1940 он. МУҮТА. ТБА. Х-1, Д-1, ХН-455, Х.1064*

**The Second Constitution of the People's Republic of Mongolia approved by the VIII State Great Hural. 1940**
*МУҮТА. ТБА. Х-1, Д-1, ХН-455, Х.1064*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



**Хоёрдугаар Үндсэн хуулийн тухай саналууд**
*1940 он. МУҮТА. УТНОНББА. Х-4, Д-8, ХН-89, Х.289-290*

**Proposals for a new constitution.1940**
*МУҮТА. УТНОНББА. Х-4, Д-8, ХН-89, Х.289-290*



**БНМАУ-ын хоёрдугаар Үндсэн хууль боловсруулах комисс**
*1940 он.*

**Constitutional Commission of the People's Republic of Mongolia. 1940**



**БНМАУ-ын хоёрдугаар Үндсэн хуулийг батлаж буй нь.**
*1940 он.*



**Adoption of the new Constitution of the People's Republic of Mongolia. 1940**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110 ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР





Паспортын нэгдсэн журмыг тогтоож, хүн ардыг бүртгэх тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 44 дүгээр хурлын тогтоол
*1940.11.22* *МУУТА. ТБА. Х-1, Д-2, ХН-766, Х.248-249*

Resolution of the 44th Summit of the Council of Ministers of the People's Republic of Mongolia on establishing a unified passport procedure and registering the population
*1940.11.22* *МУУТА. ТБА. Х-1, Д-2, ХН-766, Х.248-249*



Ард иргэдэд паспорт олгож буй нь

Issuance of passports to citizens



Хотын гудамжаар явах дүрмийг даган биелүүлэх, хяналт тавих үүргийг Улсын цагдан сэргийлэх газарт даалгасан БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 38 дугаар тогтоол
*1940.10.04* *МУУТА. ТБА. Х-1, Д-2, ХН-766, Х.145*

Resolution No. 38 of the Council of Ministers of the People's Republic of Mongolia, which instructed the Preventive Militia to comply with and monitor the rules of city streets
*1940.10.04* *МУУТА. ТБА. Х-1, Д-2, ХН-766, Х.145*



Гудамжаар явах журмыг зааварлаж буй нь. Instructing on the rules of the street

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1950 оны 5 дугаар сарын 26 ны өдөр — дугаар 126 — Улаанбаатар хот

Шүүх – прокурорын ажилтныг бэлтгэх хууль цаазын сургуулийг байгуулах тухай.

Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1/ Шүүх – прокурорын мэргэжилтэй шинэ хүчнийг бэлтгэхийн тулд, нэгэн жилийн хугацаатай байнга ажиллах хууль цаазын сургууль байгуулахыг Улсын Прокурор, Шүүх яаманд зөвшөөрөгтүгэй.

2/ Хууль цаазын сургуульд шүүх- прокурорын практиктай ажилтны дотроос элсүүлэн суралцуулах сурагчдын тоог 30 хүнээр тогтоож, тэдний цалинг тус сургуульд суралцаж буй хугацаанд урьд ажиллаж байсан газраар нь хэвээр олгож байсугай.

3/ 1950 онд хууль цаазын сургуулийн зардалд хэрэглэгдэх 101, 100 төгрөгийг улсын төсөв-эр энэ зүйлд зориулагдсан хөрөнгөнөөс гаргаж санхүүжүүлэхийг Сангийн яамны сайд н. МОЛОМЖАМЦ-д үүрэг болгосугай.

4/ Хууль цаазын сургуулийг худалдааны техникумын байранд байгуулж, түүний сурагчдын ахуй байдлын хэрэгцээг мөнхүү техникумын захиргаанаас хангаж байсугай.

Хууль цаазын сургуулийн ажиллагааг удирдах ба хариуцах явдлыг Шүүх яамны сайд н. ДАМБАДАРЖАА-д үүрэг болгож, түүнд уг сургуулийг санхүүжүүлэхээр олгосон хөрөнгийг барьж байх эрхийг олгосугай.

Ерөнхий сайд, Улсын шалгарсан Хошой баатар,
Маршал ............ (Чойбалсан)
Хэрэг Эрхлэх газрын дарга ............ (Дашдэндэв)

Шүүх, прокурорын ажилтныг бэлтгэх, Хууль цаазын сургууль байгуулах тухай Сайд нарын Зөвлөлийн 126 дугаар тогтоол
1950.05.26 МУҮТА. ТБА. Х-1, Д-4, ХН-845, Х.156

Resolution No. 126 of the Council of Ministers on the training of court and prosecutorial staff and the establishment of the School of Law
1950.05.26 МУҮТА. ТБА. Х-1, Д-4, ХН-845, Х.156



335

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1953 оны 3 дугаар сарын 14-ны өдөр — Дугаар 81 — Улаанбаатар хот

Улсын нотариатын конторыг байгуулах тухай

Улсын нотариатын дүрмийн 2 дугаар зүйлийг үндэслэн, Улсын нотариатын конторыг байгуулах тухай Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улсын нотариатын конторыг энэ оны I дүгээр улирлын дотор багтаан, Улаанбаатар хотноо байгуулахыг Шүүх яаманд зөвшөөрсүгэй.

2. Шинээр байгуулагдах нотариатын конторын орон тоо, цалингийн хэмжээг батлах ажлыг Улсын орон тооны комисст даалгасугай.

ЕРӨНХИЙ САЙДЫН ОРЛОГЧ / СҮРЭНЖАВ /

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА / БАДАРЧ /

Улсын нотариатын конторыг байгуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 81 дүгээр тогтоол
1953.03.14 МУҮТА. ТБА. Х-1, Д-5, ХН-468, Х.335

Resolution No. 81 of the Council of Ministers of the People's Republic of Mongolia on the establishment of a state notary office
1953.03.14 МУҮТА. ТБА. Х-1, Д-5, ХН-468, Х.335



Дотоод явдлын яамны төв сургууль

Central School of the Ministry of Internal



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1951 оны 5 дугаар сарын 22 ны өдөр — дугаар 116 — Улаанбаатар хот

Цагдан сэргийлэх газрын ажилтны хувцасны формын тухай

Улсын Цагдан Сэргийлэх Газрын ажилтны хувцасны формыг цэргийн хувцасны формоос ялгавартай болгох зорилгоор, БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Дотоод Явдлын Яамны харьяа Улсын Цагдан Сэргийлэх Газрын цагдаа, бага дарга, офицеруудын хувцасны шинэ формыг батласугай.

2. Энэхүү шинэ формыг 1951 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэглүүлсүгэй.

3. Улсын Цагдан Сэргийлэх Газрын ажилтны шинэ формын хувцас хийлгэхэд хэрэглэгдэх материал олгохыг Худалдааны Яамны сайд н. Лувсан-д даалгасугай.

Ерөнхий сайд, Улсын шалгарсан Хошой баатар,
Маршал ............ (Чойбалсан)
Хэрэг Эрхлэх газрын дарга ............ (Дашдэндэв)

Цагдан сэргийлэх газрын ажилтны хувцасыг цэргийн формоос ялгаатай болгох тухай Сайд нарын Зөвлөлийн 116 дугаар тогтоол
1951.05.22 МУҮТА. ТБА. Х-1, Д-5, ХН-9, Х.26

Resolution No. 116 of the Council of Ministers on differentiating the uniform of a police officer from a military uniform
1951.05.22 МУҮТА. ТБА. Х-1, Д-5, ХН-9, Х.26

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

56

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

**ТОГТООЛ**

195 5 оны 9 дугаар сарын 6-ны өдөр. Дугаар 422 Улаанбаатар хот

Шүүх, прокурорын байгууллагыг байгуулах тухай

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэд шүүх ба прокурорын байгууллагыг 1955 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулсугай.

2. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэдэх шүүх ба прокурорын байгууллагын 1955 оны орон тоо, сарын цалингийн хэмжээ, аж ахуйн зардлын төсвийг бүгд 29 100 төгрөгөөр 1,2-р хавсралтын ёсоор батлсугай.

3. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэдэх шүүх ба прокурорын байгууллагын 1955 оны зардалд зориулж, Сайд нарын Зөвлөлийн бэлтгэл хөрөнгөнөөс бүгд 29 100 төгрөг, үүнээс Шүүх Яаманд 19 600 төгрөг, Улсын прокурорын газарт 9 500 төгрөг олгосугай.

ЕРӨНХИЙ САЙДЫН 1 - Р ОРЛОГЧ / ШИРЭНДЭВ /

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА / БАДАРЧ /

цо хив. лхам.

Сайд нарын Зөвлөлийн
1955 оны 422 дугаар
тогтоолын 1-р хавсралт.

Улаанбаатарын төмөр замын газрын дэргэдэх шүүхийн 1955 оны орон тоо, сарын цалингийн хэмжээ, аж ахуйн зардлын төсөв

| № | Албан тушаалын нэр | орон тоо | сарын цалингийн хэмжээ | 10-р сараас 12-р сарыг дуустлах цалингийн фонд |
|---|---|---|---|---|
| 1 | Шүүхийн дарга | 1 | 750 | 2250 |
| 2 | Шүүгч | 1 | 530 | 1590 |
| 3 | нарийн бичгийн дарга | 2 | 400 | 2400 |
| 4 | Тогтоол гүйцэтгэгч | 1 | 400 | 1200 |
| 5 | Машины бичээч | 1 | 340 | 1020 |
| 6 | Галч-зарлага | 1 | 245 | 735 |
| | дүн | 7 | 2665 | 9195 |
| 7 | Удаан жилийн нэмэгдэл | - | 300 | 885 |
| | 1-р зүйлийн дүн | - | 2965 | 10080 |
| 1 | Соёл, гэгээрлийн шимтгэл 05 %-иар | - | - | 50 |
| 2 | Аюулаас хамгаалах шимтгэл 3 % | - | - | 300 |
| | 2-р зүйлийн дүн | - | - | 350 |
| | 1 ба 2-р зүйлийн дүн | - | - | 10430 |

| төсвийн зүйл | зардлын нэр | тоо ширхэг | нэгбүрийн үнэ | бүгд үнэ |
|---|---|---|---|---|
| 4 | Албан томилолтын зардал | - | - | 1500 |
| 12 | Бичгийн стол | 5 | 1040 | 5200 |
| | Столын цеолот хэрэглэл | 5 | 80 | 400 |
| | хагас зөөлөн сандал | 10 | 72 | 720 |
| | шкаф /бичгийн/ | 3 | 350 | 1050 |
| | жижиг эд хогшил бэлтгэх | - | - | 300 |
| | 12-р зүйлийн дүн | - | - | 7670 |
| | Цалин ба аж ахуйн төсвийн дүн | - | - | 19600 |

Сайд нарын Зөвлөлийн
1955 оны 422 дугаар
тогтоолын 2-р хавсралт.

...ын төмөр замын газрын дэргэдэх прокурорын ...он тоо, сарын цалингийн хэмжээ, аж ахуйн зардлын төсөв.

| ...эр | орон тоо | сарын цалингийн хэмжээ | 10-р сараас 12-р сарыг дуустлах цалингийн фонд |
|---|---|---|---|
| | 1 | 750 | 2250 |
| | 1 | 530 | 1590 |
| | 1 | 245 | 735 |
| дүн | 3 | - | 4575 |
| ...гдэл | - | - | 400 |
| ...-р зүйлийн дүн | - | - | 4975 |
| ...имтгэл 0 5 | - | - | 25 |
| ...шимтгэл 3 | - | - | 160 |
| 2-р зүйлийн дүн | - | - | 185 |
| ...дүн | - | - | 5160 |

| ...эр | тоо ширхэг | нэгбүрийн үнэ | бүгд үнэ |
|---|---|---|---|
| ...лтын зардал | - | - | 800 |
| | - | 1040 | 1790 |
| ...арсан стол 1) | 2 | 750 | |
| | 1 | 350 | 350 |
| ...сандил | 6 | 70 | 420 |
| ...от хэрэглэл | 2 | 80 | 160 |
| ...лэг | 4 м | 55 | 220 |
| ...л/ | 1 | 100 | 100 |
| 12-р зүйлийн дүн | - | - | 3040 |
| ...тын зардал | - | - | 500 |
| ...ахуйн зардлын дүн | - | - | 9500 |

**Шүүх прокурорын байгууллагыг байгуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 422 дугаар тогтоол**
*1955.09.06* *МУУТА. ТБА. Х-1, Д-7, ХН-79, Х.56*

**Resolution No. 422 of the Council of Ministers of the People's Republic of Mongolia on the establishment of the Judicial Prosecutor's Office**
*1955.09.06* *МУУТА. ТБА. Х-1, Д-7, ХН-79, Х.56*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС



**Ардын шүүгчдийн улсын зөвлөлгөөн.**
*1948 он*

**National Conference of People's Judges. 1948 he.**

88

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

З А Р Л И Г

1958 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр дугаар 171 Улаанбаатар хот

УЛСЫН ЦАГДАН СЭРГИЙЛЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХИЙГ ӨРГӨТГӨХ ТУХАЙ

Б Н М А Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэрэг үйлдсэн буюу нийгмийн хэв журмыг гажуудуулсан хүмүүс нь Цагдан Сэргийлэх байгууллагын ажилтнуудаас тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлбэл уул хүмүүсийн эрүүл мэндэд хоргүйгээр албадлага хэрэглэж байх эрхийг цагдан сэргийлэх байгууллагын ажилтнуудад олгосугай.

2. Гэмт хэрэгт сэжиг бүхий хүмүүсийг 48 цаг хүртэл албадан хүлээлгэж шалгах эрхийг Б Н М А Улсын Цагдан Сэргийлэх байгууллагат олгосугай. Хэрэв шаардлагатай гэж үзвэл тухайн байдлыг харгалзан уул хугацааг 24 цаг хүртэл сунгах эрхийг Б Н М А Улсын Прокурорын байгууллагат олгосугай.

3. Энэ зарлигийг биелүүлэх явдалтай холбогдох заавар батлаж гаргахыг Сайд нарын Зөвлөлд даалгасугай.

4. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 7-р сарын 28-ны өдрийн 48-р тогтоолын 8-р зүйлийг хүчингүй болгосугай.

Б Н М А УЛСЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА /САМБУУ/

Б Н М А УЛСЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /ШАРАВ/

**Улсын цагдан сэргийлэх байгууллагуудын эрхийг өргөтгөх тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 171 дүгээр зарлиг**
*1958.01.19* *МУУТА. ТБА.Х-11, Д-2, ХН-348а, Х.88*

**Decree No. 171 of the Presidium of the Parliament of the People's Republic of Mongolia on expanding the rights of state security agencies**
*1958.01.19* *МУУТА. ТБА.Х-11, Д-2, ХН-348а, Х.88*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

110

Сайд нарын Зөвлөлийн
1955 оны 129 дүгээр
тогтоолын хавсралт.

Б.Н.М.А.УЛСЫН ДОТООД ЯВДЛЫН ЯАМНЫ
ХАРЬЯА УЛСЫН ЦАГДАН СЭРГИЙЛЭХИЙН
ДҮРЭМ

I.ЕРӨНХИЙ АНГИ

I дүгээр зүйл.Улсын цагдан сэргийлэх бол олон нийтийн журам, ард иргэдийн аюулгүй байдлыг сахин хамгаалах байгууллага мөн.

Улсын цагдан сэргийлэх нь Б.Н.М.А.Улсын хууль,Засгийн Газрын тогтоол,шийдвэрүүдийг өөрийн ажилд удирдлага болгоно.

2 дугаар зүйл.Улсын цагдан сэргийлэх нь өөрийн ажлыг явуулахдаа өргөн олон ажилчин,албан хаагчид ба хөдөлмөрч ардуудыг түшиглэнэ.

Олон нийтийн журам ба ард иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах явдалд олон түмнийг оролцуулах зорилгоор цагдан сэргийлэх байгууллагууд цагдан сэргийлэхэд туслалцах сайн дурын бригадуудыг байгуулж,тэдгээрийн ажиллагааг удирдана.

II.УЛСЫН ЦАГДАН СЭРГИЙЛЭХИЙН
ЭРХ,ҮҮРЭГ

3 дугаар зүйл.Улсын цагдан сэргийлэх дор дурдсан үүргүүдийг гүйцэтгэнэ:

А.Захиргааны арга хэмжээний талаар.

а/гудамж,стадион,станц зэрэг олон түмний хөдөлгөөн бүхий бусад газарт олон нийтийн журам сахиулах явдлыг хангана;

б/нам,улс,олон нийтийн байгууллагуудаас жагсаал ба бусад арга хэмжээг зохиож байгаа үед журам сахиулах явдлыг хангана;

в/гэнэтийн аюул,халдварт өвчин гарсан тухайг зохих байгууллага ба ард олонд мэдэгдэж,уг аюултай тэмцэх явдалд ард

**БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 129 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод явдлын яамны харьяа Улсын цагдан сэргийлэхийн дүрэм**
*1955.03.29 МУУТА. ТБА. Х-1, Д-7, ХН-77, Х.497*

**Resolution No. 129 of the Council of Ministers of the People's Republic of Mongolia approving the Preventive Militia Rules**
*1955.03.29 МУУТА. ТБА. Х-1, Д-7, ХН-77, Х.497*

128

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

Зарлиг

1959 он 3 дугаар сарын 28 өдөр. дугаар 52
Улаанбаатар хот

Б Н М А УЛСЫН ШҮҮХ ЯАМЫГ ТАТАН
БУУЛГАХ ТУХАЙ

Б Н М А Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс Т О Г Т О О Х нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүх Яамыг татан буулгасугай.

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга ——— (Ж. САМБУУ)
Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга ——— (Д. БАЛЖИННЯМ)
Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга ——— (Д. ШАРАВ)

Тэргүүлэгчид: (Д. ДАМБА)
(С. ЯНЖМАА)
(М. ХАШГАМБАЙ)
(Д. ТӨМӨР-ОЧИР)

**БНМАУ-ын Шүүх яамыг татан буулгах тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 52 дугаар зарлиг**
*1959.03.28*
*МУУТА. ТБА. Х-11, Д-2, ХН-409, Х.128*

**15. Decree No. 52 of the Presidium of the Parliament of the People's Republic of Mongolia on dissolving the Ministry of Justice of the People's Republic of Mongolia**
*1959.03.28*
*МУУТА. ТБА. Х-11, Д-2, ХН-409, Х.128*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1959 оны 5 дугаар сарын 25 -ны өдөр
Дугаар 210
Улаанбаатар хот

Сайд нарын Зөвлөлд хууль
цаазны хороо байгуулах
тухай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

I.Б.Н.М.А.Улсын Шүүх Яам татан буугдсан явдалтай холбогдуулан,тус улсын хууль,хуульчилсан баримтуудыг боловсруулах,тэдгээрийг системчлэх,ангилах үүрэгтэй хууль цаазны хороог Сайд нарын Зөвлөлд байгуулсугай.

2.Хууль цаазны хорооны даргаар н. Х.ДАМДИН-г томилсугай.

3.Сайд нарын Зөвлөлийн хууль цаазны хорооны орон тоог хавсралтын ёсоор 9 нэгжээр ,сарын цалингийн фондыг 7975 төгрөгөөр баталсугай.

4.Хууль цаазны хорооны дүрмийг боловсруулан,Сайд нарын Зөвлөлөөр 7-р сарын I-ний дотор батлуулахыг н.ДАМДИН-д даалгасугай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга — ЦЭДЭНБАЛ
Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга — БАДАРЧ
Хуулбар үнэн:Тогтоол ангийн эрхлэгч — /ЛАГВАЛОРЖ/

74

Сайд нарын Зөвлөлийн 1959
оны 210 дугаар тогтоолын
хавсралт.

Сайд нарын Зөвлөлийн хууль цаазны хорооны
орон тоо,цалингийн фонд

| №§ | Албан тушаал | орон тоо | сарын цалин | сарын цалингийн фонд |
|---|---|---|---|---|
| 1 | Хорооны дарга | I | 1350 | 1350 |
| 2 | Хуулийн хорооны орлогч бөгөөд хэрэг эрхлэх газрын референт | I | 1100 | 1100 |
| 3 | Хууль цаазны мэргэжилтэн | 2 | 750-825 | 1650 |
| 4 | Хэл бичгийн мэргэжилтэн | I | 750-825 | 825 |
| 5 | Ахлах кодификатор | I | 700-[illegible] | [illegible] |
| 6 | Кодификатор | 3 | 650-750 | 2250 |
| | Бүгд | 9 | | 7975 |

**Сайд нарын Зөвлөлд Хууль цаазны хороо байгуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 210 дугаар тогтоол**
*1959.05.25 Засгийн газрын архив*

**Resolution No.210 of the Council of Ministers of the Mongolian People's Republic on the establishment of the Judicial Committee in the Council of Ministers**
*1959.05.25 Засгийн газрын архив*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



80

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ЗАРЛИГ

1960 он 5 дугаар сарын 14 өдөр, дугаар 114б

Улаанбаатар хот

Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг боловсруулах комисс байгуулах тухай

Б Н М А Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Б Н М А Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг боловсруулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын даргад:

Ю.Цэдэнбал -Сайд нарын Зөвлөлийн дарга.

Комиссын гишүүд:

Ж.Самбуу -Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга.
Л.Цэнд -МАХН-ын Төв Хорооны 2-р нарийн бичгийн дарга.
Д.Балжинням -МҮЭ-ийн Төв Зөвлөлийн дарга.
Ч.Пүрэвжав -МХЗ-ын Эвлэлийн Төв Хорооны 1-р нарийн бичгийн дарга.
С.Жалан-Аажав -Хуулийн хорооны дарга.
С.Батаа -Улаанбаатар хотын ХДХГ Захиргааны дарга.
Д.Шарав -Арьс ширний фабрикийн ажилчин.
Ц.Чойдорж -Хэнтий аймгийн „Хөдөлмөр" нэгдлийн дарга.
Ц.Дамдинсүрэн -Профессор.
Ж.Ром -Баян-Өлгий аймгийн Х Д Х -ын Гүйцэтгэх Захиргааны дарга.

**Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах комисс байгуулах тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 114б зарлиг**

*1960.05.14*

*МУУТА. ТБА. Х-11, Д-2, ХН-462, Х.68*

**Decree No. 114b of the Presidium of the Parliament of the People’s Republic of Mongolia on the establishment of the Commission to amend the Constitution**

*1960.05.14*

*МУУТА. ТБА. Х-11, Д-2, ХН-462, Х.68*



99

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

Зарлиг

1960 он 6 дугаар сарын 23 өдөр, дугаар 134

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай

Б Н М А Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Б Н М А Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг боловсруулахаар томилогдсон комиссын оруулсан үндсэн хуулийн шинэ төслийг сайшаасугай.

2.Үндсэн хуулийн шинэ төслийн талаар хөдөлмөрчдийн санал авах ажлыг эрхлэх БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн төлөөлөгчдийг аймаг, томоохон хот суурин газруудад явуулсугай.

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга (Ж. САМБУУ)
Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга (Д. БАЛЖИННЯМ)
Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /М. ХАШГАМБАЙ/
/Ц. ДАМДИНСҮРЭН/
Тэргүүлэгчид: (С. ЯНЖМАА)
(М. ХАШГАМБАЙ)
(Д. ТӨМӨР-ОЧИР)

**Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 134 дүгээр зарлиг**

*1960.06.23*

*МУУТА. ТБА. Х-11, Д-2, ХН-459а, Х.127*

**Decree No. 134 of the Presidium of the Parliament of the People’s Republic of Mongolia on amending the Constitution**

*1960.06.23*

*МУУТА. ТБА. Х-11, Д-2, ХН-459а, Х.127*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС



**БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын дарга Юмжаагийн Цэдэнбал илтгэл тавьж буй нь.**

*1960 он.*

**Tsedenbal Yumjaa, Chairman of the Commission for Drafting Amendments to the Constitution of the People’s Republic of Mongolia. 1960 he.**




**БНМАУ-ын гуравдугаар Үндсэн хуулийн төслийн Ю.Цэдэнбал даргын гарын үсэгтэй засвар хийсэн хувь**

**Revised copies of the third draft of the Constitution of the Mongolian People's Republic, signed by Chairman Yu.Tsedenbal**

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1940-1960

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



1



2



3



4



5



6

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

ШҮҮХ ЯВДЛЫН ЯАМНЫ САЙДУУД:

1 - Д.Доржпүрэв (1940-1941 он)
2 - Б.Жамбалдорж (1941-1947 он)
3 - М.Дамбадаржаа (1947-1951 он)
4 - С.Пэлжээ (1951-1956 он)
5 - С.Чойжамц (1956-1957 он)
6 - Ц.Лувсаншарав (1957-1959 он)

MINISTERS OF JUSTICE:

1 - D.Dorjpurev (1940-1941 он)
2 - B.Jambaldorj (1941-1947 он)
3 - M. Dambadarjaa (1947-1951 он)
4 - S.Peljee (1951-1956 он)
5 - S.Choijamts (1956-1957 он)
6 - Ts.Luvsansharav (1957-1959 он)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1992-2021

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат ардчилсан Үндсэн хуулийн эхийг баталгаажуулж гарын үсэг зурж, тамга дарж буй нь.
*1992.01.13*

P. Ochirbat, the first President of Mongolia, signing and stamping the new Constitution..
*1992.01.13*



Шинэ Үндсэн хуулийг батлахад БНМАУ-ын Ардын Их Хурлын 430 депутат 1991 оны 11 дүгээр сарын 11-нээс 1992 оны 1 дүгээр сарын 13-ныг дуустал 2 сар гаруй хугацаанд цэц оюунаа дайчлан ажиллажээ.

430 deputies of the People's Great Khural of the Mongolian People's Republic worked hard and diligently for more than two months from November 11, 1991 to January 13, 1992 to approve the new Constitution.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС







Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн эх
*1992 он*

Original copy of the Constitution of Mongolia
*1992 он*

110
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1992-2021

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



19

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1992 оны 8 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

Яамдын удирдлагын орон тоо, цалингийн санг батлах тухай

Монгол улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол улсын яамдын удирдлагын орон тоог сайд 1, тэргүүн дэд сайд 1 байхаар, Монгол улсын Ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний хөгжлийн газрын удирдлагын орон тоог дарга 1, тэргүүн дэд дарга 1 байхаар тус тус тогтоосугай.

2.Монгол улсын яамд, Ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний хөгжлийн газрын аппаратад болон Засгийн газрын Тамгын газарт тогтвортой мөрдөх сарын цалингийн санг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2 дугаар хавсралтад дурдсан тогтоол, тогтоолын заалт, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол улсын Ерөнхий сайд П.ЖАСРАЙ

Монгол улсын Ерөнхий сайдын орлогч Ч.ПҮРЭВДОРЖ

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн дагуу Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ энэ тогтоолоор яамны нэрийг Монгол Улсын Хууль зүйн яам болгожээ.
*1992.08.27* *Засгийн газрын архив*

In accordance with the new Constitution of Mongolia the Government, in exercising its authority, changed the name of the Ministry to the Ministry of Justice of Mongolia by this resolution.
*1992.08.27* *Засгийн газрын архив*



Хууль зүйн сайдын 1993 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн 99 дугаар тушаалын 1 хавсралт.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ БҮТЭЦ



Хууль зүйн яамны бүтэц
*1993.05.04.*
*МУУТА. ТБА. Х.284. Д.8. ХН.38. Тал 179.*

Annex to Order No. 99 of the Minister of Justice, which approved the structural scheme of the Ministry of Justice
*1993.05.04. МУУТА. ТБА. Х.284. Д.8. ХН.38. Тал 179.*



37

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1996 оны 12 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 297 | Улаанбаатар хот

Агентлаг байгуулах тухай

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай" Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын дор дурдсан хэрэгжүүлэгч агентлаг байгуулсугай:

а/Үндэсний архивын газар;

б/Оюуны өмчийн газар;

в/Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв.

2.Агентлагийн тухай хууль батлагдах хүртэл дээрх байгууллагуудын түр дүрэм, орон тоо, төсөв, цалингийн санг Сангийн яамтай тохиролцсоны үндсэн дээр баталж мөрдүүлэхийг Хууль зүйн сайд Ж.Амарсанаад даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Архивын ажлыг сайжруулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1984 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл, "Архивын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 259 дүгээр тогтоолын 3, 6 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

Хууль зүйн сайд Ж.АМАРСАНАА

ХЗЯ-ны харьяа агентлагуудыг байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол
*1996.12.05*
*Засгийн газрын архив*

Resolution No. 297 of the Government of Mongolia on the establishment of implementing agencies such as the National Archives, the Intellectual Property Office, and the State Center for Civil Registration and Information within the scope of work of the Minister of Justice
*1996.12.05* *Засгийн газрын архив*



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1997 оны 2 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 42 | Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай

"Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 1 дэх заалт, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай" Улсын Их Хурлын 1996 оны 40 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар байгуулсугай.

2.Агентлагийн тухай хууль батлагдах хүртэл Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газрын түр дүрэм, орон тоо, төсөв, цалингийн санг Сангийн сайдтай тохиролцсоны үндсэн дээр баталж мөрдүүлэхийг Хууль зүйн сайд Ж.Амарсанаад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХСАЙХАН

Хууль зүйн сайд Ж.АМАРСАНАА

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол
*1997.02.12* *Засгийн газрын архив*

Resolution No. 42 of the Government of Mongolia on Establishment of the Real Estate Registry within the scope of work of the Minister of Justice
*1997.02.12* *асгийн газрын архив*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

15

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН**

**Т О Г Т О О Л**

2000 оны 8 дугаар сарын 23-ны өдөр — Дугаар 131 — Улаанбаатар хот

Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Яамдын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

Ерөнхий чиг үүргийн яамд:

а/Гадаад хэргийн яам:

-Хөрш орнуудын газар;

-Ази, Америкийн газар;

-Европ, Араб, Африкийн газар;

-Олон талт хамтын ажиллагааны газар /Олон талт хамтын ажиллагааны нэгдүгээр хэлтэс, Олон талт хамтын ажиллагааны хоёрдугаар хэлтэстэй/;

-Төрийн захиргааны удирдлагын газар /Хүний нөөцийн хэлтэс, Захиргааны хэлтэс, Харилцаа холбооны хэлтэс, Санхүү, аж ахуйн хэлтэстэй/;

-Эрх зүй, консулын газар /Консулын хэлтэс, Эрх зүйн хэлтэс, Хилийн тасагтай/;

-Бодлого, төлөвлөлт, мэдээлэл, үнэлгээний газар /Хэвлэл мэдээллийн хэлтэс, Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Орчуулгын хэлтэстэй/;

-Ёслолын хэлтэс.

б/Санхүү, эдийн засгийн яам:

-Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар;

-Төсвийн бодлого, зохицуулалтын газар;

16

2

-Төрийн захиргааны удирдлагын газар;

-Төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газар;

-Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газар;

-Салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газар;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Нягтлан бодох бүртгэлийн хэлтэстэй/.

в/Хууль зүй, дотоод хэргийн яам:

-Хууль зүйн бодлогын газар;

-Төрийн захиргааны удирдлагын газар /Гадаад харилцааны хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Шалган зааварлах хэлтэстэй/;

-Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

Чиглэлийн яамд:

г/Байгаль орчны яам:

-Стратегийн төлөвлөлт, удирдлагын газар;

-Төрийн захиргааны удирдлага, мэдээллийн газар /Санхүү, аж ахуйн хэлтэстэй/;

-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын хэлтэстэй/;

-Байгаль орчны улсын хяналт, үнэлгээний газар;

-Хамтын ажиллагааны хэлтэс /Олон улсын төслийн албатай/.

д/Батлан хамгаалах яам:

-Стратегийн төлөвлөлт, удирдлагын газар /Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Улсын дайчилгааны хэлтэс, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй/;

20

6

з/"Хууль зүйн яамны зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл;

и/"Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 174 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл.

Монгол Улсын Ерөнхий сайд — Н.ЭНХБАЯР

Засгийн газрын гишүүн,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга — Ө.ЭНХТҮВШИН

ҮХА 0064

**Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Хууль зүйн яамны бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөн Хууль зүй, дотоод хэргийн яам болгосон.**
*2000.08.23* *Засгийн газрын архив*

**The structure and organization of the Ministry of Justice was expanded by this Government resolution to the Ministry of Justice and Home Affairs.**
*2000.08.23* *Засгийн газрын архив*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС




**Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зохион байгуулалтын бүтэц**
*2001 он* *МУУТА. ТБА. Х.284. Д.9. ХН.62. Тал 87*

**Organization structure of the Ministry of Justice and Home affairs of Mongolia. 2001**
*МУУТА. ТБА. Х.284. Д.9. ХН.62. Тал 87*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

110

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

# 1992-2021

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ХАМТ ОЛОНД

*Мэндчилгээ*

*Монгол Улсад хууль зүйн алба үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан тус албаны үе үеийн ахмадууд, нийт ажилтнуудад баярын мэндчилгээ дэвшүүлье.*

*Монгол Улсын хууль зүйн алба нь түүхэн хөгжлийнхөө явцад улс орондоо хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, эрх зүйн зохистой тогтолцоог бүрдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулж ирснийг тэмдэглэхэд таатай байна.*

*Хууль зүйн албыг улам бэхжүүлж, Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн оновчтой зохион байгуулах, зах зээлийн эдийн засгийн харилцааны онцлогт тохируулж түүний гүйцэтгэх үүргийг төгөлдөржүүлэх, ялангуяа хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх байнгын механизмыг бий болгох талаар санаачилгатай ажиллах хэрэгтэй байна.*

*Эрх зүйн шинэтгэлийг цаашид гүнзгийрүүлж, хууль хамгаалах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хуулиудыг батлуулах, эдгээр хуулиудыг нэг мөр, цаг алдалгүй хэрэгжүүлэх нь нийгмийн захиалга, хэрэгцээ боллоо.*

*Шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлж, шүүхийн боловсон хүчин, зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээтэй холбоотой асуудлуудыг дэс дараатай, оновчтой шийдвэрлэх шаардлагатай байна.*

*Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах бодлогын хүрээнд сахилга, дэг журмыг чанд сахиулж, бүх шатанд хариуцлагын тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлж архидан согтуурах явдалтай хийх тэмцлийн эрч далайцыг нэмэгдүүлэн, энэ ажилд бүх нийтийн хүч, анхаарлыг төвлөрүүлэн ажиллавал зохино.*

*Тэрчлэн манай нийгэмд ноцтой аюул занал учруулах авилгалын бүх хэлбэртэй шийдвэртэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар төр, засгийн холбогдох байгууллагуудтай хамтран иж бүрэн арга хэмжээг өөрийн орны онцлогт тохируулан авч хэрэгжүүлэх нь тус албаны хамт олны хүч, анхаарлаа зайлшгүй төвлөрүүлэх асуудлын нэг гэдгийг онцлон тэмдэглэж байна.*

*Хууль зүйн албаны түүхэн тэмдэглэлт ойг тохиолдуулан тус албаны хамт олонд хууль цаазат ёсыг төлөвшүүлэх, шударга үнэнийг хамгаалагч байх эрхэм үйлсдээ улам их амжилт гаргаж эрүүл энх, цог хиймортой байхын ерөөлийг дэвшүүлье.*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — НАЦАГИЙН БАГАБАНДИ

Улаанбаатар хот — 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

**Хууль зүйн албаны 80 жилийн ойн баярт Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн ирүүлсэн баярын илгээлт**

*2001.11.30*

*ХЗДХЯ-ны хүндэт самбараас.*

**Congratulatory message from the President of Mongolia N.Bagabandi on the 80th anniversary of the Legal Service**

*2001.11.30*

*ХЗДХЯ-ны хүндэт самбараас.*

ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТНУУДЫН
"ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ"
СЭДЭВТ УУЛЗАЛТ-ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДООС
ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад Хууль зүйн алба байгуулагдсаны 80 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Хууль зүйн албаны тэргүүний ажилтнуудын уулзалт- ярилцлага 2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо боллоо.

Уулзалт, ярилцлагад "Хууль зүйн албаны үүсэл, хөгжлийн түүхэн замнал" /Б.Цэвээн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн/, "Хууль зүйн албаны онолын тулгамдсан асуудал" /И.Дашням, МУИС-ийн профессор/, "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарах асуудал" /А.Энхжав, ИБМУТөвийн дарга/, "Эрх зүйн сурталчилгааны шинэлэг хэлбэрийн асуудал" /Д.Мөнхгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга/ сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүллээ.

"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-т заасанчлан төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, ард түмэндээ үр нөлөөтэй, шуурхай үйлчилж, тэдний үндсэн хэрэгцээг хангах, шударга ёсыг хэвшүүлэх, сайн засаглалыг бүрдүүлэх зорилт болон уулзалт-ярилцлага дээр тавьж хэлэлцүүлсэн илтгэлүүд, тэдгээртэй холбогдуулж хэлсэн үг, санал, шүүмжлэлийн дагуу уулзалт-ярилцлагад оролцогчдоос нутаг дэвсгэр, салбарын хэмжээнд Хууль зүйн албыг бэхжүүлэх, төгөлдөржүүлэх асуудлын талаар ЗӨВЛӨМЖ гаргах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. Хууль зүйн албаны зорилт, чиг үүрэг, үйл ажиллагааны хэтийн төлөв, бүтцийг оновчтой болгож, тэдгээрээс хүн амд үзүүлэх үйлчилгээний чанар, шуурхай байдлыг хангах;
2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлагийн орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн эрх, үүргийг өргөтгөх, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;
3. Орон нутгийн хууль зүйн албаны ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах асуудлыг тусгайлан авч үзэж төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх;
4. Хууль тогтоомжийн мэдээллээр хангах зорилгоор шалган туслах, хууль тогтоомжийн хэрэгжилт, эрх зүйн үйлчилгээний үр нөлөөнд хяналт-шинжилгээ хийж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг гаргуулах арга хэмжээг салбар, орон нутгийн хууль зүйн албаны хүрээнд эхлүүлж, тогтмолжуулах арга хэмжээ авах;

**Хууль зүйн албаны 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан Хууль зүйн тэргүүний ажилтнуудын уулзалт- ярилцлагын урилга, хурлаас гаргасан зөвлөмж**

*2001.06.15 МУУТА. ТБА. Х.284. Д.9. ХН.62. Тал 35, 42-43*



ХУУЛЬ ЗҮЙН АЛБАНЫ 80 ЖИЛ

*Хууль зүйн албаны тэргүүний ажилтнуудын уулзалт- ярилцлага*

Урилга

Улаанбаатар хот
2001.6.15

5. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах арга хэлбэрээ орон нутаг, сурталчилгаанд хамрагдагсдын онцлогийг үндэслэн зөв сонгох, төрийн бус байгууллагын оролцоог өргөжүүлэх арга хэмжээг орон нутагт түлхүү анхаарч, зохион байгуулах, төрийн захиргааны албан хаагч бүр хууль тогтоомж сурталчлагч байна гэсэн зарчмыг хэрэгжүүлэх арга механизмыг бүрдүүлэх;
6. Хууль боловсруулах үйл ажиллагаанд салбарын болон нутаг дэвсгэрийн хууль зүйн албаны албан хаагчдыг татан оролцуулах асуудлыг тогтмолжуулах, тэдэнд тавих шаардлагыг өндөржүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;
7. Хууль зүйн албаны тэргүүний ажилтан ахмадуудын туршлагыг залгамж халаа болсон залуучуудад өвлүүлэх, эзэмшүүлэх чиглэлээр бүсчилсэн уулзалт-ярилцлагыг зохион байгуулж байх;
8. Хууль, эрх зүйн актыг системчилж, боловсронгуй болгох арга хэмжээг шинэ нөхцөлд нийцүүлэн зохион байгуулах;
9. Хувийн сектор болон салбарын удирдлагын хүрээнд хууль зүйн албыг бэхжүүлэх асуудалд анхаарч зохион байгуулалтын арга хэмжээ авах;
10. Хүн амын эрх зүйн мэдээлэл, боловсролын түвшинд судалгаа хийх;

УУЛЗАЛТ-ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧИД

2001 ОНЫ 6 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР

УЛААНБААТАР ХОТ.

**Invitation to the meeting of the Legal Officers and recommendations from the meeting organized within the framework of the 80th anniversary of the Ministry of Justice**

*2001.06.15 МУУТА. ТБА. Х.284. Д.9. ХН.62. Тал 35, 42-43*

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
МОНГОЛ УЛС

